

ЦССҮТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтэд
хийсэн хяналт шинжилгээний танилцуулга

2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр.

Үнэлгээний зорилго

Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт үнэлгээ хийж, хүрсэн түвшнийг тогтоох, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг үнэлэх, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

Үнэлгээний арга зүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ий өдрийн А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх нийтлэг журмыг тус тус үндэслэн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт-шинжилгээ

Төв нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хийсэн хяналт шинжилгээг хүснэгтээр харуулав.

А) Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу хийсэн үнэлгээ

№	Байгууллага	Зорилтын тоо	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ							Дундаж хувь
				100	90	80	70	60	50	30	
1.	Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт	4	57	27	2	5	3	2	9	6	74,4 %

Анхаарах нь:

1. Төлөвлөлт сайжраад байгаа хэдий ч 1 зорилт дотроо хэд хэд задарсан, нийтлэг зорилтыг стратеги төлөвлөгөөтэй уялдуулсан нь дугаар логик байдал ойлгомжгүй байдал хэвээр байна. Зорилтоо тодорхой болгоод түүний дагуу үйл ажиллагааг уялдуулж гаргасан бол төвийн үндсэн болон дэмжих үйл ажиллагаанууд тодорхой ойлгомжтой болох саналыг 2024 оны жилийн эцэст зөвлөмжинд тусгагдсан ч засагдаагүй байна.
2. Зарим үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт оновчгүй, хэрэгжилтийг үнэлэхэд тохиромжгүй байна
3. Тайланг ойлгомжтой, товч тодорхой шалгуурын дагуу байх бичигдэхэд анхаарах
4. Зарим алба, тасгийн тайлан бүрэн бичмгдээгүй байна
5. Тоон үзүүлэлтийг хугацаанаас эрт авсан тул үнэлгээг зөв хийхэд нөлөөлж байна.
- 6.

Дүгнэлт.

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулж ЭМЯ, төрийн захиргааны удирдлагын газраас аргазүйн зөвлөгөө авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж хугацаанд нь батлуулж, хэрэгжүүлж ажилласан;
2. Эхний хагас жилд нийт 57 үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн. 4 үйл ажиллагаа 3,4-р улиралд төлөвлөсөн тул эхний хагас жилийн үнэлгээд орсонгүй.
3. Алба тасгууд хэргэжилтээ тодорхой үнэлж хувилаагүй тул нийт оноог гаргахад бэрхшээлтэй байв.
4. Хяналт шинжилгээгээр 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилээр **74,4%** байна
5. Бүрэн биелсэн 7 үйл ажиллагаа 47,4%, 10 үйл ажиллагаа 70% иас дээш үнэлгээтэй 17,5%, 17 үйл ажиллагаа 60% иас бага гүйцэтгэлтэй байна.
6. Огт биелээгүй буюу биелэлтээ тайлагнаагүй:
 - Цусны донор аппликейшн хөгжүүлэлт хийж, үйл ажиллагааг тогтмолжуулах
 - Төвийн гамшиг НЭМ-ийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн төлөвлөгөөнд тодтгол хийж, батлуулан хэрэгжилтийг хангах

- Төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 6647:2017 стандартыг шинэчлэн батлуулах
 - Гемофилийн ТҮ хамтарсан төсөр хэрэгжүүлэх зэрэг байна.
7. Алба тасгууд дотооддоо ярилцаж үр дүн хэрэгжилтийн хувийг тодорхой гаргаагүй
 8. Хийсэн зарим ажлууд дутуу тусгагдсан байгаа тул холбогдох алба, тасаг эргэн харж тодруулга нэмэлт хийх

Цаашид авах арга хэмжээ.

1. Хамт олны хөдөлмөр тул хийсэн ажлыг тайланд бүрэн тусгаж, тодорхой оновчтой байхад, зарим алба тасаг хамт олноор сайн хэлэлцүүлж хэвшихэд анхаарах
2. Жилийн турш үргэлжлэн хийх ажлыг улирал бүрээр тодорхой хэмждэг болох
3. Гүйцэтгэл дутуу байгаа ажлуудыг 3,4-р улиралд нөхөн бүрэн хэрэгжүүлэх
4. Шинэлэг зүйлс, сайн туршлага, дотоод хамтын ажиллагааг сайжруулах НМ-ийн тогтолцооны стандартын 7,4 харилцаа холбоог сайжруулах ажлыг тусгахад анхаарах нь зүйтэй байна.

ДОТООД АУДИТОР Т. АЛИМАА

2025.06.26.